

# САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА

\*\*\*БАНКНЫ САЛБАР\*\*\*

2021 ОН



## Агуулга

### 1. Танилцуулга

- Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ ? Яагаад чухал гэж ?.....4

### 2. Санхүүгийн хүртээмж.....7

- Данстай иргэд;

- Хүргэх суваг;

- Хэрэглээ.

### 3. Сорилтууд .....17

- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бусад байгууллагын оролцоо чухал байна;

- Тусгайлсан үйлчилгээний хэрэгцээ байна;

- Системийн өөрчлөлт шаардлагатай байна;

- Санхүүгийн боловсрол;

- Банкнууд үйлчилгээгээ илүү хялбар болгох шаардлагатай байна.

### 4. Дүгнэлт, зөвлөмж.....20

## Өмнөх үг

Эрхэм уншигч таны амар амгаланг айлтгая!

Банк санхүүгийн академи нь 2021 оноос эхлэн судалгааны албатай болон өргөжиж Монгол Улсын банк, санхүүгийн зах зээлд шаардалагатай судалгааг боловсруулж олон нийтэд танилцуулах болсон.

Энэ удаад Монголын банкны холбоо 2014 оноос хойш жил бүр уламжлал болгон танилцуулдаг санхүүгийн хүртээмжийн судалгааг хамтран боловсруулж олон нийтэд танилцуулж байна. Энэхүү судалгааг боловсруулахад тоон мэдээллээр хангаж ажилласан 11 арилжааны банкны хамт олонд гүн талархал илэрхийлье.

Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхээс гадна эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй. Тиймээс ч дэлхийн ихэнх улсууд санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг олон төрлийн аргачлалын дагуу хэмжин тухайн үзүүлэлтүүдийг бусад улсуудтай харьцуулах байдлаар санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд илүү хялбар, хурдан шуурхай, зардал багатайгаар хүргэх стратеги, төлөвлөгөөг боловсруулах болжээ. Энэхүү судалгааны ажлын зорилго нь манай улсын санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг тодорхойлох, санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд тулгарч буй асуудлыг тайлбарлах, хэрхэн үр ашигтай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд банкны оролцоо чухал ач холбогдолтой болохыг харуулах билээ.

Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөө, шаардлагаар банкны салбарт хурдтайгаар дижитал шилжилт хийх шаардлага үүсэв. Гэвч нөгөө талдаа мэдээллийн технологийн үр шимийг хүртэх боломжгүй нийгмийн хэсэг /малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай өрхүүд гэх мэт/ дээрх үйлчилгээнээс хоцрох, амьдралын нөхцөл байдал сайжрахгүй бол бүр хүртэж чадахгүй болох эрсдэл учирч байна.

Иймээс бид санхүүгийн хүртээмжийн судалгаагаар дамжуулан банк, хувийн хэвшил, төрийн байгууллагууд санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг сайжруулахад хэрхэн хамтарч ажиллах, санхүүгийн хүртээмжийг мэдээллийн технологи ашиглан сайжруулах боломжийн талаар дүгнэлт хэсэгт дурдсан.

Уншигч Та энэхүү судалгааны ажлын талаарх санал бодлоо Банк санхүүгийн академи болон Монголын банкны холбоонд ирүүлбэл бид ихэд талархах болно.

Хүндэтгэсэн,

Банк санхүүгийн академийн

Гүйцэтгэх захирал Г.Бумчимэг

## Танилцуулга

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэх, санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан иргэдийн амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд дэлхий нийтээр анхаарлаа хандуулж байна. Өөрөөр хэлбэл мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан хурдан шуурхай, зардал бага, хэрэглэгч бүрд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэдэд санал болгох болжээ.

Манай улсын хувьд төрөөс олгодог тэтгэвэр, тэтгэмжийн нөлөөгөөр насанд хүрсэн хүн амд эзлэх банканд данстай иргэдийн хувь дэлхийн хөгжингүй улсуудын түвшинд байдаг. Гэсэн хэдий ч манай улсын 3 хүн тутмын нэг, ажил эрхэлж буй иргэдийн 22 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна.<sup>1</sup>

Манай улсад мэдээллийн технологийн дэвшлийг сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй ашиглах болсон нь иргэдэд хурдан

шуурхай, хялбар байдлаар банкны үйлчилгээг хүртэх боломжийг бүрдүүлж буй хэдий ч нөгөө талдаа санхүүгийн үйлчилгээг дижитал хэлбэрээр ашиглах боломжгүй иргэд (малчид, тариаланчид гэх мэт), хөгжлийн бэрхшээлтэй болон бага орлоготой иргэдэд санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх боломжгүй эрсдэлтэй нөхцөл байдал руу шилжиж байна.

Түүнчлэн сүүлийн 2 жил ковид-19-ийн нөлөөгөөр эдийн засгийн ихэнх салбарууд зогсонги байдалтай, нийгмийн харилцаа хязгаарлагдмал байдалд шилжсэнээр иргэдийн санхүүгийн чадавх багасаж, үүнийг дагаад банкны зарим үйлчилгээг тухайлбал зээл авах суурь шаардлагыг хангах иргэдийн тоо буурч эхэлсэн.

Энэ удаагийн санхүүгийн хүртээмжийн судалгаа нь өмнөх жилүүдэд хийгдсэн судалгаанаас дараах байдлаар ялгаатай. Үүнд

I. Санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг хэмжих

үзүүлэлтүүд манай улсад ямар түвшинд байгааг бусад улстай харьцуулсан;

II. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ манай улсын иргэдэд хэрхэн хүрч буйг харуулсан;

III. Санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд учирч буй сорилтууд, түүнийг хэрхэн даван туулах талаар тусгасан.



<sup>1</sup> Үндэсний статистикийн хороо

# Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

“Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн бүрд хялбар, тэгш хүртэх боломжийг энгийнээр санхүүгийн хүртээмжтэй байдал гэнэ”

Санхүүгийн байгууллагын хөгжил, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж дэлхийн ихэнх улсуудад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ иргэдэд харилцан адилгүй хүрдэг. Өөрөөр хэлбэл тухайн иргэний нас хүйс, нийгмийн гарал үүсэл, хөгжлийн бэрхшээлтэй байдлаас хамаарч санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломж харилцан адилгүй байдаг.

Санхүүгийн байгууллагууд зээлийн түүх үүсээгүй, орлогын эх үүсвэр нь тодорхой бус иргэдэд итгэх итгэл бага байдгаас шалтгаалж орлого багатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломж хязгаарлагдмал болдог. Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх гэдэг бол дээр дурдсан эмзэг нөхцөл байдалд байгаа иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ойртуулах, санхүүгийн байгууллагаар тогтмол үйлчлүүлдэг

болгох явдал юм. Тиймээс дэлхийн ихэнх улсуудад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан дээрх иргэдэд зориулсан аюулгүй, найдвартай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргахын сацуу санхүүгийн хүртээмжийн гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулах болсон. Өөрөөр хэлбэл санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хялбар, зардал багатай хүргэх нь тэдгээр иргэдийг санхүүгийн хүнд нөхцөл байдлаас гаргахад нөлөөлөхөөс гадна эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал нөлөөтэй.

Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн ихэнх салбарууд зогсонги байдалд орж, удаан үргэлжилсэн хөл хорио нь иргэдийн орлогод шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлсөн. Ялангуяа орлого багатай иргэд, ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхүүдийн нөхцөл байдал хүнд байна. Дэлхийн ихэнх улсууд цар тахлын нөхцөл байдлаас энгийн горимд шилжихэд нийгэм, эдийн засгийн хувьд хүндхэн

сорилттой тулгарах нь зайлшгүй болоод байна. Иймд энэ цаг үед санхүүгийн хүртээмжийн судалгааг боловсруулах нь нийгэм, эдийн засгийн хувьд чухал ач холбогдолтой. Үүнд:

## Хэрэглэгч иргэдийн хувьд

2020 оны байдлаар манай улсын 3 хүн тутмын нэг нь ядуурлын шугамаас доош хэрэглээтэй байна.<sup>2</sup>

“Ковид-19 ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогоын өөрчлөлтийн түүвэр судалгаан”-д<sup>3</sup> оролцогчдын 73 хувь нь цар тахлын нөхцөл байдал гэр бүлийн орлогод маш их сөргөөр нөлөөлсөн гэж хариулжээ. Орлогын түвшингээр авч үзвэл 400 мянган төгрөг хүртэлх орлоготой иргэдэд хамгийн их сөргөөр нөлөөлжээ. Түүнчлэн судалгаанд хамрагдсан иргэдийн 72 хувь нь хадгаламжгүй, 14 хувь нь 1 сар, 8 хувь нь 3 сарын хугацаанд хуримтлалаараа амьдрах боломжтой гэжээ.<sup>4</sup> Олон хоногийн үргэлжилсэн хөл хорионоос үүдэлтэй бодит орлого буурснаас шалтгаалж иргэдийн сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутрал, стрессийн түвшин



## Танилцуулга

Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



Дүгнэтл,  
Зөвлөмж



Хавсралт



2 Үндэсний статистикийн хороо, www.1212.mn

3 Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим

4 Ковид-19 Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлт түүвэр судалгаа, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (2020 он)

## Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

нэмэгдсэн.<sup>5</sup> Иймд банкууд иргэдэд хэрэглээгээ хэрхэн зохицуулах, өрийн дарамтаас хэрхэн сэргийлэх, учирч болзошгүй бусад санхүүгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч байна. Өөрөөр хэлбэл иргэн бүрд тохирсон технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн хүртээмжийг сайжруулахын сацуу банкны үйл ажиллагааг өргөжүүлэх, хэрэглэгчдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлэх ажлуудыг шат дараатайгаар авч хэрэгжүүлэх

байна.

### Банкны хувьд

Банкуудын нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл нь эргээд тухайн банкны үнэ цэнийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн банканд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Иргэд үйлчлүүлэх банкаа сонгохдоо тухайн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэхэд хялбар байдлаас гадна нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөлийг харгалзан үздэг болжээ. Мэдээллийн технологийн

дэвшлийг ашиглан иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зардал багатай, хурдан шуурхай хүргэх нь банкны үнэ цэнийг улам нэмэгдүүлж байна. Иймээс банкууд бүхий л үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн хөгжлийг ашиглан дижитал банкны хэлбэр лүү хурдацтай шилжих болжээ.

### Хөрөнгө оруулагчийн хувьд

Ирэх 1 жилийн хугацаанд системийн нөлөө бүхий банкууд

### Танилцуулга

Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



Дүгнэлт



Зөвлөмж

Хавсралт



### Санхүүгийн хүртээмжтэй байдал Монгол Улсад—2021<sup>6</sup>



**140,000**

орчим хүн банканд дансгүй



**181,052**

Малчин иргэдийн 70% нь зээл, хадгаламийн данстай



**200,451**

байгууллагаас 50% нь банканд данстай



**3 ХҮН ТУТМЫН**

нэг нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй



**ДӨРВӨН**

хүн тутмын нэг нь хадгаламжтай



**108,399**

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 5 хүн тутмын нэг нь банкаар дамжуулж тэтгэмж авдаггүй

<sup>5</sup> Ковид-19 цар тахлын үеийн олон нийтийн төсөөлөл, сэтгэл зүй, зан үйл судалгааны тайлан, АУШҮИС, НЭМС, ЭМНАНУТ

<sup>6</sup> Үндэсний статистикийн хороо, Монгол банк, банкнуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн тооцоолсон.

# Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжинэ. Өөрөөр хэлбэл дотоодын хөрөнгө оруулагчдад банкны хувьцаа нээлттэй болно.

Олон улсын судалгаанаас харахад банканд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчид нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт буюу ESG(Байгаль орчин, нийгэм, засаглал) хөрөнгө оруулалтыг илүү сонирхох болжээ. Тогтвортой байдал буюу байгаль орчин, нийгэм болон засаглалын хүчин зүйлсийг чухалчлан үздэг хувьцаат компаниудад хөрөнгө оруулах хандлага нэмэгдсэн. Иймээс санхүүгийн хүртээмжийг сайжруулах нь банкны хувьд нийгмийн тогтвортой байдал, нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд авч хэрэгжүүлж буй ESG арга хэмжээнүүдийн нэг юм.

## Ажилчдын оролцоо

Банкны салбарт ур чадвартай, сэтгэлтэй боловсон хүчин тасралтгүй ажиллах нь санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Учир нь ур чадвартай

боловсон хүчин нь тухайн харилцагчийн боловсрол, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл зэргээс үл хамааран хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг ойлгон санхүүгийн боломжит үйлчилгээг үзүүлэх чадамжтай байдаг.

## Зохицуулагч байгууллагууд

Монгол Улсын 2016-2030 оны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасны дагуу нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад зохицуулагч байгууллагууд хамтран, зорилтуудыг хэрэгжүүлж эхлээд нилээдгүй хугацааг өнгөрчээ. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.3 хэсэгт “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэсний дагуу ирэх жилүүдэд технологид суурилсан бичил санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж ажиллах төлөвтэй байна. Манай улсын хувьд

зохицуулагч байгууллагуудын тогтвортой хөгжлийг хангах үзүүлэлтүүдийг сайжруулах тал дээр нэгдсэн байр суурьтай байгаа нь давуу тал болж байна.

## Нийгэм, эдийн засаг

Өмнө нь дурдсанчлан цар тахлын нөхцөл байдал удаан үргэлжилбэл ажилгүйдлийн түвшин нэмэгдэх, иргэдийн бодит орлого багасах, банкны үйлчилгээг хүртэх боломжгүй нөхцөл байдалд буй иргэд улам бүр нийгмийн харилцаанаас шахагдах аюул тулгараад байна. Иймээс Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөг даван туулахад банкны оролцоо чухал нөлөөтэй юм. Учир нь банк иргэдэд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйчлилгээг хүргэх боломжтой санхүүгийн хамгийн чухал институцын нэг юм.



### Танилцуулга

Санхүүгийн хүртээмжтэй байдал гэж юу вэ? Яагаад чухал гэж?

Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



Дүгнэлт,  
Зөвлөмж



Хавсралт



# Санхүүгийн хүртээмж

Манай улс 2 шатлалт банкны тогтолцоонд шилжсэнээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг банкаар дамжуулан хүргэх боломж нээгдсэн. Тиймээс энэхүү хэсэгт манай улсын хувьд санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд хэр түвшинд байгааг бусад улсуудтай харьцуулан харуулахыг зорилоо.

## Банканд данстай иргэд

Нийт хүн амын хичнээн хувь нь санхүүгийн байгууллагад данстай байгаагаар тухайн улсын

санхүүгийн хүртээмжийг нэн тэргүүнд хэмждэг.

Дэлхийн банкнаас 4 жил тутам гаргадаг “The Global Findex Database” буюу санхүүгийн хүртээмжийн судалгаанаас харахад манай улсын насанд хүрсэн хүн амын 94% нь банканд данстай байгаа нь бусад улсуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.<sup>7</sup> Тухайлбал, насанд хүрсэн хүн амын дундах данс эзэмшиж буй иргэдийн тоогоор Япон улсаас 4 нэгжээр, бүс нутгийн сонгосон улсуудтай харьцуулахад өндөр байгааг доорх

зургаар харуулав. Манай улсын 25-аас дээш настай иргэдийн 96 хувь нь банканд данстай бол 14-24 насны иргэдийн 84 хувь нь банканд данстай байна. Банкинд данстай иргэдийг хүйсээр авч үзвэл манай улсад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10 хувиар илүү байна.

## Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх суваг

Банканд данстай иргэдийн эзлэх хувь хөгжингүй улсуудтай ижил түвшинд байгаа нь нэг талаас төр иргэдэд олон төрлийн тэтгэвэр,



Эх үүсвэр: World bank, Global Findex database

7 Дэлхийн банк, Global Findex database—2017

9 Монголбанк

8 Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн

10 Дэлхийн банк, Global Findex database—2017

- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

## Санхүүгийн хүртээмж

тэтгэмж, урамшуулал олгосоор ирсэнтэй холбоотой бол нөгөө талаас банкууд иргэн бүрд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тэгш хүргэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж ирсэний үр дүн юм.

Тиймээс банкнууд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд (иргэн болон байгууллага) хэрхэн хүргэж буйг харуулах нь чухал ач холбогдолтой. Дэлхийн банкны хүртээмжийн судалгаанаас харахад манай улсын насанд хүрсэн 100,000 хүн тутамд


60 банкны салбар, нэгж оногдож буй нь дэлхийн хөгжингүй улсуудаас өндөр үзүүлэлт бол 100,000 хүнд оногдох АТМ-ийн тоо 47 байгаа нь Япон, Хятад, Казахстан улсуудаас 2-3 дахин бага байна.

Нийт салбар, нэгжийн 71 хувь нь хөдөө орон нутагт, АТМ-ын 72 хувь нь Улаанбаатар хотод байршдаг. Өөрөөр хэлбэл банкнууд хүн амын бүтэц, газар нутгийн онцлогийг харгалзан бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэдэд хүргэсээр иржээ.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн

технологийн хөгжил хурдацтай явагдаж, үүнийг дагаад иргэдийн амьдралын хэв маягт мөн томоохон өөрчлөлтүүд гарч байгаагийн нэг нь банканд биеэр очиж үйлчлүүлэх иргэдийн тоо жилээс жилд багасаж ухаалаг төхөөрөмжүүд ашиглан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх болжээ. Өөрөөр хэлбэл цаашид банкны салбар, нэгжээр үйлчлүүлэх иргэдийн тоо тогтмол буурч мэдээллийн технологийн дэвшилд тулгуурласан ухаалаг системийг иргэд түлхүү хэрэглэх хандлагатай байна. Манай

100,000 хүнд оногдох банкны салбар, нэгж болон АТМ-ын тоо



Эх үүсвэр: World bank

### Хүргэх суваг



Салбар, нэгжийн

**50% нь сумын төвд<sup>11</sup>**



ПОС машины тоо сүүлийн 2 жилд

**30% нь өсөв<sup>12</sup>**



КИОСК машины тоо сүүлийн 2 жилд

**2 дахин нэмэгдэв<sup>13</sup>**

<sup>11</sup> Монголбанк

<sup>13</sup> Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн

<sup>12</sup> Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн



- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ



## Санхүүгийн хүртээмж

улсын хувьд сүүлийн жилүүдэд АТМ-ын тоо буурч буй хэдий ч банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг доороос авах боломжтой КИОСК машины тоо жил ирэх тутам нэмэгдэж байна.

Иргэд АТМ, СДМ, КИОСК, ПОС зэрэг төхөөрөмж ашиглахаас гадна интернет банк, мобайл банк зэрэг ухаалаг гар утас, төхөөрөмжийн тусламжтайгаар орон зай, цаг хугацаа үл хамааран банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүссэн үедээ авах сонирхолтой болжээ. Өөрөөр хэлбэл финтек буюу

технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх, түүнийг өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болгон ашиглах сонирхолтой хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Тухайлбал, манай улсын интернет банк эзэмшигчдийн тоо 2019 оноос 3 дахин, мобайл банк эзэмшигчдийн тоо 7 дахин өсжээ. Нийт интернет банк эзэмшигчдийн 70 хувь өдөр тутмын амьдралдаа тогтмол интернэт банк ашигладаг бол банкууд өөрсдийн апплэйкшн, интернет банкаар дамжуулан гар

утасны төлбөр төлөх, киноны тасалбар худалдаж авах, хэрэглээний төлбөр төлөх, онлайн дэлгүүрээс худалдан авалт хийх зэрэг дунджаар 7 нэр төрлийн үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгодог байна. Судалгаанд хамрагдсан 11 банкны 9 нь интернет банкаар дамжуулан шинээр данс нээх боломжтой гэжээ.

Цаашид мэдээллийн технологийн хөгжлийн хурдац, түүнийг дагаад иргэдийн амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлтөд тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн,

### Хүргэх суваг



#### 9 банк

интернет банкаар дамжуулан данс нээх боломжтой



#### Дунджаар 7 төрлийн


үйлчилгээг интернет банкаар дамжуулан хүргэж байна.



#### Иргэдийн 70% нь

тогтмол интернет банк ашиглаж байна.

### Интернет банк, мобайл банк хэрэглэгч



Эх үүсвэр: Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн



### Танилцуулга

### Санхүүгийн хүртээмж



- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

### Сорилтууд



### Дүгнэлт,

### Зөвлөмж



### Хавсралт



# Санхүүгийн хүртээмж

үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх нь банкуудын хувьд томоохон сорилт болж байна.

## Бүтээгдэхүүн, үйлчилгээ


Санхүүгийн хүртээмжийг нэг талаас банканд данстай иргэдийн тоогоор хэмждэг бол нөгөө талаас тухайн дансаар дамжуулан хэрхэн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол хэрэглэж буйгаар нь хэмждэг. Тухайлбал дижитал банк, мобайл банк, төлбөрийн карт болон бусад төрлийн үйлчилгээ нь санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг хэрэглээ, ашиглалт талаас нь хэмждэг үзүүлэлтүүдийн талаар авч үзье.

## Данс эзэмшигчид

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн ихэнх салбарууд уналтад орсон тул төрөөс 2021 онд иргэдийн эрүүл мэндийг дэмжих мөнгөн тэтгэмж олгосонтой холбоотойгоор насанд хүрсэн хүн амын 94 хувь нь банканд данстай болжээ. Мөн жижиг дунд

үйлдвэрлэгч нарт зориулсан “10 их нааядын зээлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлснээр зээлийн данстай жижиг дунд үйлдвэрлэгчдийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.6 дахин нэмэгджээ. Гэсэн ч насанд хүрсэн хүн амын 4 орчим хувь банканд дансгүй хэвээр байна. Яагаад банканд дансгүй байгаа талаар нарийвчилсан судалгаа байхгүй хэдий ч олон улсын санхүүгийн хүртээмжийн судалгаанаас харахад нийгмийн эмзэг бүлэг, хөдөө орон нутгийн

иргэд, тусгай хэрэгцээтэй хүмүүс, жижиг дунд үйлдвэрлэгчид ихэвчлэн банканд дансгүй үлддэг. Учир нь тэдгээр иргэдийн дийлэнх нь санхүүгийн боловсрол багатай, олж буй орлого нь бага тул бэлэн хэлбэрээр хадгалах, хэрэглэх сонирхол өндөртэй байдаг. Иймд банканд дансгүй байх, банканд дансаа тогтмол ашиглахгүй байх нь дээрх нөхцөл байдалд байгаа иргэдийг ядуурал руу улам хөтлөх, цаашлаад хөдөлмөрийн мөлжлөг, хууль бус хөдөлмөр эрхлэлт зэрэг



Эх үүсвэр: Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн

## Танилцуулга

### Санхүүгийн хүртээмж

- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

### Сорилтууд

Дүгнэлт,  
Зөвлөмж

Хавсралт

## Санхүүгийн хүртээмж

гэмт хэргийн шинжтэй үйлдлийн золиос болгоход нөлөөлдөг.

### Төлбөр тооцоо


Насанд хүрсэн хүн амын дийлэнх нь банканд данстай байна гэдэг нь санхүүгийн хүртээмжийг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг хэдий ч тэдгээр иргэдийн хэчнээн нь дансаа тогтмол үр ашигтай ашиглаж буйг тодорхойлох шаардлагатай. Манай улсын хувьд нийт данстай иргэдийн 38 хувь нь төлбөр тооцоог дижитал хэлбэрээр буюу интернет банк, мобайл

банкаар дамжуулан гүйцэтгэж байгаа бол 47 хувь нь бусад дижитал хэлбэр буюу АТМ, КИОСК, ПОС зэрэг төхөөрөмжөөр, 15 хувь нь уламжлалт аргаар буюу бэлэн мөнгөөр гүйцэтгэж байна. Банканд данстай иргэдийн төлбөр тооцоо хийж буй хэлбэрийг сонгосон бусад улсуудтай харьцуулахад манай улс Хятад улсаас 2 нэгжээр бага, Япон улсаас 5 нэгж, Казахстан улсаас 20 нэгжээр илүү дижитал төлбөр тооцоог хийдэг. Бусад дижитал төлбөр тооцооны хувьд манай улс Япон

улсаас бага, сонгосон улсуудаас өндөр үзүүлэлттэй байна. Мэдээллийн технологийн хөгжил, технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжихийн хирээр уламжлалт төлбөр тооцооны хэрэгсэлээс ухаалаг төхөөрөмжид суурилсан төлбөр тооцоо, дижитал төлбөр тооцоо руу аажмаар шилжиж байна. Учир нь төлбөр тооцоог дижитал хэлбэрээр гүйцэтгэх нь эдийн засгийн болон эдийн засгийн бус олон хэмнэлтийг үүсгэдэг.

Банкуудаас ирүүлсэн тоон

Төлбөр тооцоо гүйцэтгэж буй байдал—2017 он



Эх үүсвэр: World bank, Global Findex database—2017



### Танилцуулга

#### Санхүүгийн хүртээмж



- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

#### Сорилтууд



Дүгнэлт,  
Зөвлөмж



Хавсралт




# Санхүүгийн хүртээмж

мэдээллээс харахад манай улсын хувьд сүүлийн 2 жилийн хугацаанд уламжлалт төлбөр тооцооны хэрэгслээс дижитал хэлбэрт асар хурдацтай шилжилт хийж байна. Тухайлбал 2019 банканд данстай нэг иргэн жилд дунджаар 24 удаа банканд очиж үйлчилгээ авдаг байсан бол 2020 онд 20 болж буурсан. Мөн 2019 онд банканд данстай нэг иргэн жилд дунджаар 54 удаа АТМ-ээр үйлчлүүлдэг байсан бол 2020 онд 44 болон буурчээ. Харин банканд данстай нэг иргэн 2019 онд интернет банк,

апплейкшнээр дамжуулан 58 гүйлгээг дунджаар хийж гүйцэтгэдэг байсан бол 2020 онд 94 болж өсжээ. Дижитал төлбөр тооцоо эрчимтэй хийгдэх болсон нэг шалтгаан нь сүүлийн жилүүдэд манай улсад онлайн дэлгүүр, онлайн худалдан авалт, төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэх дэд бүтэц хурдацтайгаар бүрэлдэж буйтай холбоотой юм. Дижитал төлбөр тооцоог тогтмол хийж гүйцэтгэснээр тухайн хэрэглэгчид урт хугацааны

санхүүгийн түүх үүсэх бөгөөд түүнд тулгуурлан банкууд хэрэглэгч бүрт уян хатан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх боломж бүрдэж байгаа бол нөгөө талаас хэрэглэгчдийн хувьд дижитал төлбөр тооцооны түүхээ харан өөрийн санхүүгээ зөв зохистой удирдах, санхүүгийн сахилга баттай болох боломж бүрдэж байна. **Хадгаламж** Иргэд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, урт хугацаанд боловсрол болон бизнесийн үйл

Банканд данстай нэг хүний жилд хийсэн дундаж гүйлгээний тоо



Эх үүсвэр: Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн


# Санхүүгийн хүртээмж

ажиллагаанд хөрөнгө оруулах гэх мэт олон төрлийн зорилгоор хуримтлалыг үүсгэдэг. Хөгжингүй улсуудын банканд данстай иргэдийн 21 хувь нь санхүүгийн байгууллагад албан ёсоор хадгаламж үүсгэдэг байна.<sup>14</sup> Албан ёсны хадгаламж гэдэг нь санхүүгийн байгууллага буюу банк болон хадгаламж зээлийн хоршоонд тодорхой хугацаанд тогтмол хуримтлал буй болгохыг ойлгох бол албан бус хадгаламж гэдэгт гэртээ хадгалах, бусдад зээлүүлэх гэх мэт санхүүгийн байгууллагаар дамжаагүй

хуримтлалын хэлбэрийг ойлгож болно. Банканд данстай иргэн бүр хадгаламжтай байх боломжгүй тул тухайн иргэдэд хадгаламжийн үр ашгийн талаар тогтмол сургалт зохион байгуулах, санхүүгийн боловсролыг урт хугацаанд нэмэгдүүлэх шаардлага үүсдэг. Манай улсын хадгаламжийн данстай иргэдийн тоо жил бүр нэмэгдэж буй хэдий ч тогтмол хадгаламж үүсгэдэг хэрэглэгчийн тоо бага байна. Нэг хүнд оногдох хадгаламжийн дүнгээр уул уурхай, үйлдвэрлэл хөгжиж буй Дархан,

Эрдэнэт, Өмнөговь аймгийн иргэд бусад аймагтай харьцуулахад өндөр байна.

Түүнчлэн хадгаламж тогтмол бий болгох, хадгаламжийн дансыг зохистой ашиглах нь нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас гадна тухайн улсад санхүүгийн зах зээл хэрхэн хөгжиж буйгаас шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагууд иргэдэд ирээдүйд учир болзошгүй санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн аливаа



14 Global Findex database

## Санхүүгийн хүртээмж


асуудлыг хэрхэн зохицуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс шууд хамаардаг. Манай улсын банканд данстай иргэдийн 9 хувь нь санхүүгийн байгууллагад хадгаламжтай бол 46 хувь нь албан бус хэлбэрээр буюу гэртээ хадгалах, танил садандаа зээлүүлэх гэх мэтчилэн хадгалдаг байна. Үлдсэн 45 хувь нь хадгаламжгүй. Сонгосон улсуудтай харьцуулахад санхүүгийн байгууллагад хадгаламжтай иргэдийн хувь бага түвшинд байна.

Нийгмийн эмзэг бүлгийн хэчнээн хувь нь хадгаламжийн данстай эсэх талаар мэдээлэл байдаггүй. Харин нийт хадгаламжийн дүнг хүйсээр харвал манай улсын эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 6 хувиар илүү хадгаламжтай байна.<sup>15</sup>

### Зээл

Иргэд орон сууц, газар, авто машин зэрэг өндөр дүнтэй, ирээдүйд хөрөнгө оруулалт болохоор зүйлсийг худалдан авахаар ихэвчлэн санхүүгийн байгууллагаас зээл авдаг бол өдөр тутмын хэрэглээний зээлийг албан бус хэлбэрээр буюу найз нөхөд, гэр бүл, танил хүмүүсээс зээлдэг байна. Гэвч мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөгөөр өдөр тутмын хэрэглээнд шаардлагатай бага дүнтэй зээлийг ч иргэд санхүүгийн байгууллагаас өөрийн ухаалаг

Иргэдийн хадгалах хандлага



Эх үүсвэр: World bank, Global Findex database

### Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ



#### 11 банк

интернет банкаар дамжуулан зээлийн үйлчилгээг санал болгож байна.



#### 2 төрлийн зээлийн үйлчилгээ

(цалин болон хадгаламж барьцаалсан зээл)-ийг банк гар утасны апплейкшнээр дамжуулан олгодог.



#### 22 ББСБ

финтект суурилсан зээл олгож байна.



### Танилцуулга

#### Санхүүгийн хүртээмж



- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

#### Сорилтууд



#### Хүртээмжийг нэмэгдүүлэх боломж



#### Хавсралт




## Санхүүгийн хүртээмж

утас, төхөөрөмж ашиглан авах боломжтой болсон. Манай улсад арилжааны 11 банк интернет банкаар дамжуулан цалингийн болон хадгаламж барьцаалсан зээлийг олгож байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд финтект суурилсан зээлийн үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагууд хөгжүүлэн иргэдэд хурдан шуурхай, хэрэглэхэд хялбар байдлаар хүргэж байна.


Иймд манай улсын иргэд аль эх үүсвэрээс ихэвчлэн зээл авч буйг судлах нь сонирхолтой. Дэлхийн банкны хүртээмжийн судалгаанаас харахад манай улсын иргэдийн 30 хувь нь санхүүгийн байгууллагаас, 18 хувь нь гэр бүлээсээ, 52 хувь нь бусад эх үүсвэрээс зээл авдаг. Япон улсын иргэдийн хувьд гэр бүлээс зээлдэг хувь маш бага, санхүүгийн байгууллагаас зээлдэг хувь бусад сонгосон улстай харьцуулахад өндөр байна.

Монгол улсын иргэдийн банкнаас авч буй зээлийн бүтцийг харвал нийт зээлийн 29% хэрэглээний зээлд зориулж байгаа бол кредит картын зээл (хүү тооцоогүй) ердөө 1% байна. Япон улсад кредит картын зээл банкны зээлийн 48 хувийг эзэлдэг, Хятад улсад 14 хувийг тус тус эзэлдэг байна. Зээлийн үйлчилгээ нь иргэдийг санхүүгийн

Иргэд хаанаас зээл авдаг вэ?



Иргэд санхүүгийн байгууллагаас авсан зээлийн бүтэц



Эх үүсвэр: World bank, Global Findex database—2017



### Танилцуулга

#### Санхүүгийн хүртээмж

- Данстай иргэд
- Хүргэх суваг
- Хэрэглээ

#### Сорилтууд

#### Хүртээмжийг нэмэгдүүлэх боломж

#### Хавсралт

# Санхүүгийн хүртээмж


асуудлаа шийдвэрлэх, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс зайлсхийх, түүнчлэн орлого багатай өрхүүдийг ядуурлаас гаргах боломжтой чухал бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн нэг юм.

Цаашид банкны зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд кредит картны зээл чухал үүрэгтэй байхаар байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхийн нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдалд шилжсэнээс хойш шинээр олгосон иргэдийн

зээлийн дүн буурсан хэдий ч технологид суурилсан зээл нэмэгджээ. Учир нь иргэд банканд оочирлож цаг хугацаа алдахын оронд өөрийн гар утас, интернет банкыг ашиглан түргэн шуурхай, зардал багатай зээл авахыг илүүд үзэх болжээ. Банкнуудын хувьд интернет банк, апплейкшнээр дамжуулан олгож буй зээлийн дундаж хэмжээ нь 1.399 сая төгрөг байгаа бол ББСБ-уудын апплейкшнээр олгосон зээлийн 70 орчим хувь нь 1 сая төгрөг дотор

байна.<sup>16</sup> Өөрөөр хэлбэл орлогын эх үүсвэр нь тодорхой, банкны үйлчилгээг тогтмол ашигладаг иргэдийн хувьд урт хугацааны хөрөнгө оруулалт хэлбэрээр орон сууцны зээл, автомашины зээл болон бусад хэрэглээний зээлийг авдаг бол орлого тодорхой бус, эсхүл орлого багатай өдөр тутамд санхүүгийн ямарваа нэгэн бэрхшээлтэй иргэдийн хувьд бага дүнтэй уян хатан зээлээр өөрийн санхүүгээ зохицуулах сонирхол байдаг хэдий ч банкнуудын зээл

Шинээр олгосон зээлийн хэмжээ (тэрбум төгрөгөөр)



Эх үүсвэр: Судалгааны үр дүн, 11 банкны нийлбэр дүн

16 Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн хүртээмжийн судалгаа, 2021-8 сар

## Санхүүгийн хүртээмжийн сорилтууд

Санхүүгийн хүртээмжийн судалгааг боловсруулснаар манай улсын санхүүгийн салбар тэр дундаа банкны салбарт санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрэл хэр түвшинд байгааг харуулах, цаашид санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд ямар төрлийн сорилтууд тулгарч болох тэдгээрийг хэрхэн даван туулах боломжийн талаар танилцуулах юм. Ковид-19 цар тахал нөхцөл байдлаас шалтгаалж хүмүүсийн амьдралын хэв маягт томоохон өөрчлөлт ороод зогсохгүй бүхий л салбарт цахимжилт асар хурдацтайгаар нэмэгдсэн.

Санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрлийг нэмэгдүүлэхэд бүхий л төрлийн байгууллагуудын оролцоо чухал.

Манай улсын насанд хүрсэн хүн амын дийлэнх нь банканд данстай хэдий ч 3 хүн тутмын нэг нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна. Өөрөөр хэлбэл манай улсын банк санхүүгийн байгууллага дунд болон дундаас дээш орлоготой хэсэг

бүлэгт л зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажиллаж байна. Иймд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол хэрэглэж чадахгүй байгаа бүлэгт хэрхэн хүрч ажиллах нь чухал юм. Санхүүгийн байгууллагууд дангаар нийгмийн эмзэг бүлэг, хөдөө орон нутгийн иргэд, тусгай хэрэгцээтэй хүмүүст хүрч ажиллах боломжгүй байдаг. Учир нь дээрх иргэдийн талаарх нарийн мэдээлэл, судалгаа санхүүгийн байгууллагуудад байдаггүй. Нөгөө талаас ихэнх сайн дурын байгууллагууд тухайн иргэний амьдралын нөхцөл байдалд л ихэвчлэн анхаарал хандуулдаг. Иймд нийгмийн эмзэг бүлэг, тусгай хэрэгцээтэй хүмүүст тусалцаа үзүүлдэг сайн дурын байгууллагуудтай хамтран дээрх иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулахаас гадна тэдгээр иргэдийн талаарх мэдээллийг цуглуулж, тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох боломжтой.

Санхүүгийн байгууллагууд болон

олон нийтийн сайн дурын байгууллагууд хамтарч ажиллаж чадвал тодорхой хэмжээнд нийгмийн эмзэг бүлэг, хөдөө орон нутаг болон тусгай хэрэгцээтэй хүмүүсийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Тусгайлсан үйлчилгээний хэрэгцээ байна.

Орлогын эх үүсвэр нь тодорхой бус, өнөөдрийн хэрэгцээт хүнсээ хэрхэн олох талаар бодож байгаа нийгмийн эмзэг бүлгийн хүмүүсийн дийлэнхд нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдэх сонирхол үнэндээ төрөхгүй. Тиймээс тэдгээр иргэдтэй уулздаг сайн дурын байгууллагын ажилчдын санхүүгийн боловсролыг нэн тэргүүнд сайжруулан түүгээр дамжуулан дээрх иргэдийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэх боломжтой. Ийнхүү санхүүгийн боловсрол олгосноор дээрх эмзэг бүлгийн иргэд санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх, санхүүгийн хэрэгцээгээ тодорхой хэмжээнд санхүүгийн



Танилцуулга

Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бусад байгууллагын оролцоо чухал байна.
- Тусгайлсан үйлчилгээний хэрэгцээ байна.
- Системийн өөрчлөлт шаардлагатай байна.
- Санхүүгийн боловсрол
- Банкнууд үйлчилгээгээ илүү хялбар болгох шаардлагатай байна

Хүртээмжийг нэмэгдүүлэх боломж



Хавсралт



# Санхүүгийн хүртээмжийн сорилтууд

байгууллагаас авах боломж бололцоо бүрдэх юм.

Эмзэг бүлэгт хүргэх сувгаа нэмэгдүүлэх, сайжруулах

Банкнууд өөрсдийн үндсэн хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түлхүү хөгжүүлж иржээ. Гэвч цар тахлын нөхцөл байдлын улмаас иргэдийн хэрэгцээнд өөрчлөлт орж үүнийг дагаад уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ буурч байна. Иймээс банкнууд өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулахдаа эмзэг бүлгийн иргэдэд хүртэл хүртээмжтэй байхаар шийдвэрлэвэл санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна өөрсдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх боломжтой юм.

Мөн мэдээллийн технологийн хөгжил, банкны дижиталжилт нь тусгай хэрэгцээтэй иргэд, дэд бүтэц муутай алслагдсан хөдөө орон нутгийн иргэдийг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс улам холдуулж байна. Өөрөөр хэлбэл

банк тодорхой бүлэг хүмүүст үйлчилдэг санхүүгийн байгууллага болон хувирч байна. Ингэснээр бага орлоготой, нийгмийн эмзэг бүлгийн иргэд тухайн байгууллагад эрсдэл өндөртэй хэрэглэгч болон харагдах юм. Банкнуудын зээлийн апплейкшнүүд тухайн иргэдийн орлогод үндэслэн зээл олгож буй нь учир дутагдалтай байна. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэн хувиараа бизнес хийн тогтмол биш орлого олдог бол тухайн зээлийн апплейкшн тухайн иргэнийг тогтмол орлогогүй гэдэг талаас харах бөгөөд хувь хүн нь хэн бэ гэдгийг таних боломжгүй юм. Иймээс мэдээлэл технологийн хөгжил нийгмийн бүхий л салбарт хөгжиж буй хэдий ч зарим талаараа бүлэг хүмүүсийг нийгмээс тусгаарлах үйл явц хийгдэж байна.

## Санхүүгийн боловсролыг дэмжих

Санхүүгийн боловсрол олгох хичээл, сургалтаар дамжуулан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тухайн иргэнд санхүүгээ удирдах, санхүүгийн бэрхшээлээс гарахад туслах, санхүүгийн хувьд

эрх чөлөөтэй байхад тусалдаг талаар сайн ойлгуулах хэрэгтэй.

Банкны зарим үйлчилгээг илүү хялбар болгох шаардлага байна.

Манай улсын иргэдийн 18 хувь нь гэр бүл найз нөхдөөс зээл авдаг бол 52 хувь нь албан бус эх сурвалжаас зээл авч буй тухай дурдсан. Банкнаас зээл авахад шаардлага өндөртэй, банкнаас авч буй зээл нь эргээд тэр иргэнд дарамт болж магадгүй гэдэг үүднээс хандаж байгаа учир албан бус эх сурвалжаас зээл авч байна. Тийм учраас банкнууд энэхүү ойлголтын зөрүүг багасгаж чадахгүй бол мэдээллийн технологийн хөгжил нь банкны үйлчилгээг авч чадахгүй байгаа иргэдийг банкны үйлчилгээнээс улам л холдуулсаар байх болно. Түүнчлэн банкнууд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхдээ ямар хэрэглэгчид энэхүү үйлчилгээг хүртэх боломжгүй талаар судалж байх хэрэгцээ үүсэж байна. Тухайлбал, зээлийн үйлчилгээг дан ганц интернет банк, апплейкшнээр дамжуулан олгодог болвол өндөр



Танилцуулга

Санхүүгийн хүртээмж

## Сорилтууд

- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бусад байгууллагын оролцоо чухал
- Тусгайлсан үйлчилгээ
- Системийн өөрчлөлт шаардлагатай байна
- Санхүүгийн боловсрол
- Банкнууд үйлчилгээгээ илүү хялбар болгох шаардлагатай байна

Хүртээмжийг нэмэгдүүлэх боломж

Хавсралт

## Санхүүгийн хүртээмжийн сорилтууд

настай иргэд, алслагдсан хөдөө орон нутгийн иргэд хэрхэн тэрхүү үйлчилгээг гар утас, ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан авах вэ гэдэг асуултай тулгарч байна.

Банк хэдийгээр хэрэглэгчдийн талаар маш өргөн хэмжээний дата сантай, түүнийг ашиглан тооцоо судалгаа хийж буй хэдий ч тухайн хэрэглэгчийн талаар бүрэн мэдэх боломжгүй юм. Тиймээс аливаа шинэчлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлтийг хийхийн өмнө нь энэ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой билүү, эсхүл аль бүлгийн иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүргэхэд төвөгтэй болгож буй талаар байнга бодолцож байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл банк нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн ч санхүүгийн хэрэгцээг нь хангаж ажилладаг байх санхүүгийн салбарын хамгийн том институт юм.



Танилцуулга



Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бусад байгууллагын оролцоо чухал
- Тусгайлсан үйлчилгээ
- Системийн өөрчлөлт шаардлагатай байна
- Санхүүгийн боловсрол
- Банкнууд үйлчилгээгээ илүү хялбар болгох шаардлагатай байна

Хүртээмжийг  
нэмэгдүүлэх боломж



Хавсралт



## Дүгнэлт

### Банкны үйлчилгээ

Манай улсын насанд хүрсэн хүн амын 94 хувь нь банканд данстай байгаа нь сонгосон улсуудтай харьцуулахад санхүүгийн хүртээмж боломжийн түвшинд байна.

Сүүлийн жилүүдэд мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөгөөр банкаар үйлчлүүлж буй иргэдийн тоо жил ирэх тутам буурч, ухаалаг төхөөрөмж, интернет банк хэрэглэгчдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байна.

Интернет банк хэрэглэгчийн тоо 2019 онтой харьцуулахад 3 дахин, мобайл банк хэрэглэгчдийн тоо 7 дахин өсжээ. Үүнийг дагаад хэрэглэгчид мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг гар утас, ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан авах сонирхолтой болжээ.

Үүнийг дагаад сүүлийн жилүүдэд дижитал хэлбэрээр төлбөр тооцоо хийх, дижитал үйлчилгээг хүртэх иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна.

### Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ

Банканд данстай иргэдийн төгрөгийн хуримтлал бий болгох хандлагыг нэмэгдүүлэх, түүнийг иргэдэд төлөвшүүлэх нь чухал байна. Манай улсын иргэдийн хадгалах хандлага бусад сонгосон улсуудтай харьцуулахад бага түвшинд байна.

Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдээллийн технологийн дэвшлийг ашигласан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэх, одоогийн үйлчилгээг боловсронгуй болгох шаардлагатай тулгарч байна.

Сонгосон улсуудтай харьцуулахад банкнаас иргэдэд олгосон кредит картны зээл бага хувийг эзэлж байна. Кредит картны зээлийн үйлчилгээг хөгжүүлэх, кредит картны зээлийн өгөөжийн талаар сурталчлах шаардлагатай байна.

### Хөдөлмөрийн бүтээмж

Мэдээллийн технологи хөгжихийн хирээр банкны нэгж ажилтны хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэж, харилцагчдад илүү их хүрч

ажиллахыг боломжийг бүрдүүлж байна.

### Ирээдүйн чиг хандлага

Манай улсын хувьд одоогийн банканд данстай иргэдийн тоог хэвээр хадгалах, цаашид технологид тулгуурласан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх замаар банканд данстай иргэдийг тогтмол банкаар үйлчлүүлдэг болоход анхаарч ажиллах шаардлага байна. Иймд дараах хүчин зүйлсийг анхаарч ажиллаж чадвал манай улсын санхүүгийн хүртээмж, түүний гүнзгийрэл улам нэмэгдэх боломжтой. Үүнд:

#### Ковид-19-ийн нөлөө

Удаан үргэлжилсэн хөл хорионоос үүдэлтэйгээр эдийн засгийн ихэнх салбаруудад зогсонги байдалд орсноор хэрэглэгчид санхүүгийн болон сэтгэл зүйн хувьд тогтворгүй болж эхэлсэн. Тийм ч учраас ихэнх улсуудын төв банк, арилжааны банкууд харилцагчийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан зээлийн эргэн төлөлт, зээлийн ангилалд



Танилцуулга



Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



Дүгнэлт



Ирээдүйн, чиг хандлага

Хавсралт



# Дүгнэлт

өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээ авчээ. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр банкнууд технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд асар хурдацтай нийлүүлж дижитал шилжилтийг алхам алхмаар хийж байна. Банкнуудын дижитал шилжилт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар ковидын дараах эдийн засгийн сэргэлтэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.

## Тусгайлсан банк

Банканд иргэдийн маш олон төрлийн тоон мэдээлэл хуримтлагддаг. Үүнийг орчин үеийн мэдээллийн технологийн хөгжилтэй холбон тухайн хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл уламжлалт аргачлалын дагуу хэрэглэгч бүрд нэгдсэн шалгуур тавих нь мэдээллийн технологи өндөр түвшинд хөгжиж буй өнөө цагт тохиромжгүй юм. Иймд банкнууд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд

гаргахын өмнө санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг хэмжих боломж бүрдэж байна.

## Туслах үйлчилгээ

Мэдээллийн технологийн тусламжтайгаар банкны хэрэглэгч бүрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох боломж бүрдэж буй хэдий ч зарим иргэд банкны үйлчилгээний гадна үлдэх эрсдэл бий. Тухайлбал нийгмийн эмзэг бүлгийн иргэд гар утас, ухаалаг төхөөрөмж ашигладаггүй бол тэдгээр иргэдэд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл, мэдлэг олгох тусгайлсан үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй болдог. Иймд туслах үйлчилгээг дан ганц банкны салбар хийгээд зогсохгүй, нийгмийн сайн дурын байгууллагуудтай хамтран гүйцэтгэвэл үр дүнгээ өгдөг. Банкны туслах үйлчилгээний баг хэрэглэгчдийн банканд байгаа тоон мэдээллийг ашиглан тухайн иргэний эрсдэлийг тодорхойлсны дараагаар нийгмийн эмзэг бүлэгт үйлчилдэг сайн дурын байгууллагатай хамтран ажиллах

шаардлага гарч байна. Туслах үйлчилгээ нь дан ганц санхүүгийн үйлчилгээг хүртэж чадахгүй иргэдэд туслахаас гадна нийгмийн бусад хэсгийг санхүүгийн мэдлэгээр цэнэглэх боломжтой юм.

## Санхүүгийн боловсролыг түгээх

Санхүүгийн боловсролыг маш энгийнээр иргэдэд түгээж, хүргэх шаардлагатай тулгарч байна. Хувь хүн өөрийн санхүүгийн боломжид тулгуурлан хамгийн сайн санхүүгийн шийдвэр гаргахад юуг анхаарах ёстойг энгийнээр тайлбарлаж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл иргэн өөрийн амьдралын хэв маягт тохирсон санхүүгийн шийдвэрүүдийг гаргадаг байхад л болох юм. Иргэд санхүүгийн боловсрол дутмаг байдлаас шалтгаалж санхүүгийн буруу шийдвэр гаргах, өрийн дарамтад унах зэрэг эрсдэл үүсдэг. Санхүүгийн боловсрол олгох үйл явцыг тасралтгүй иргэдэд олгож байх нь санхүүгийн хүртээмжийг өндөр түвшинд байлгах чухал хүчин зүйл юм.



Танилцуулга


Санхүүгийн хүртээмж

Сорилтууд

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралт



## Эх сурвалж:

1. Deloitte, Growth through financial inclusion—A road map to UK banks, 2021
2. World bank, The Global Findex database, 2017
3. АУШҮИС, НЭМС, ЭМНАНУТ, Ковид-19 цар тахлын үеийн олон нийтийн төсөөлөл, сэтгэл зүй, зан үйл судалгааны тайлан
4. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Ковид-19 Ажлын байрнаас хамаарах иргэдийн орлогын өөрчлөлт түүвэр судалгаа, 2020 он
5. Санхүүгийн зохицуулах хороо, Хүртээмжтэй санхүү сэтгүүл, 2021-8
6. Үндэсний статистикийн хороо, Монголбанк, банкуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн тооцоолсон.
7. Эн ар си си, Монгол улсын санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа, 2018



Танилцуулга



Санхүүгийн хүртээмж



Сорилтууд



Дүгнэлт

Зөвлөмж



Хавсралт

